



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 08 өдөр

Дугаар А/626

Хэрлэн сум

Гэр бүлийн сургалт, гарын авлага
хэвлүүлэх ажилд хөрөнгө зарцуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Төрийн бус байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэнтий аймгийн Ахмад багш нарын “Хан Хэнтийхэн” холбооноос сургалтын байгууллагын суралцагчдын эцэг эхчүүд үр хүүхэдтэйгээ ажиллах арга барил, эв дүй сурган хүмүүжүүлэх нэгдлийг хангуулж идэвхжүүлэхэд чиглэгдсэн Гэр бүлийн сургалт, гарын авлага хэвлүүлэх ажилд зориулан 18,400,000 (арван найман сая дөрвөн зуун мянган) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний “Төр-Иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх” зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Зоригтбаатар)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2023
оны 12 дугаар сарын 08-ны
D/626 дугаар захирамжийн хавсралт

ЗАРЦУУЛАЛТЫН ТООЦОО

№	Зардлын төрөл	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Сургуулийн өмнөх боловсрол-гарын авлага	204	16,500	3,336,000
2	Анхан шатны боловсрол-гарын авлага	310	16,500	5,115,000
3	Суурь боловсрол-гарын авлага	219	16,000	3,504,000
4	Ерөнхий боловсрол-гарын авлага	92	18,300	1,683,600
5	Сумдаар "Гэр бүлийн сургалт" зохион байгуулах зардал		4,761,400	,4,761,400
	Нийт			18,400,000